

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШУУРХАЙ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2019.06.03

№

Дархан

Аймгийн Засаг даргын Шуурхай хурал 2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 08:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хуралдааны танхимд эхлэв. Сум, хэлтэс, агентлагийн удирдлагууд 2019 оны 05 дугаар сарын 27-31-ний өдрүүдэд зохион байгуулсан ажил болон 2019 оны 06 дугаар сарын 03-07-ний өдрүүдэд хийж хэрэгжүүлэх ажлын талаар мэдээлэл хийв.

Аймгийн Засаг даргын орлогч А.Түвшинбат: ЧИГЛЭЛ, ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

Нийт удирдлагууд: 2019 оны 06 дугаар сарын 04-ний өдөр Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын сайд Дархан-Уул аймагт ажиллах гэж буйтай холбогдуулан ерөнхий төлөвлөгөө гарсан. Уг төлөвлөгөөний дагуу тус өдөр БСШУС-ын сайд 16:00 цагаас 18:00 цагийн хооронд аймгийн боловсрол, соёл, урлагийн салбарын ажилтнуудтай уулзалт хийнэ. Иймд орон нутгийн холбогдох удирдах албан тушаалтнууд хуваарийн дагуу оролцоно. Мөн өдрийн 18:00 цагаас 19:00 цагийн хооронд боловсролын чиглэлээр Дархан-Уул аймагт хийгдэж буй хөрөнгө оруулалтын ажлын явцтай танилцана. Иймд холбогдох удирдлагууд Спорт цогцолборын барилгын ажлын одоогийн нөхцөл байдал болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай танилцуулж мэдээлэл өгөх хэрэгтэй байна.

Аймгийн Засаг даргын орлогч Т.Ганболд: ЧИГЛЭЛ, ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

Нийт удирдлагууд: Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын урьдчилсан үзлэгийг баг ажлаа эхлүүлж байна. Мөн сумдууд жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төслийн зарлалыг сайн түгээх хэрэгтэй байна. Түүнчлэн энэ 7 хоногт хөрөнгө оруулалт, хөдөө аж ахуй, зам тээвэр, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төсөл болон өвөлжилтийн хэрхэн давсан тухай асуудлаар хэвлэлийн бага хурал хийх төлөвлөгөөтэй байна. Иймд холбогдох хэлтэс, агентлагийн дарга нар хэвлэлийн бага хуралд оролцож иргэд олон нийтэд мэдээлэл өгөх хэрэгтэй.

Аймгийн Засаг дарга С.Насанбат: ЧИГЛЭЛ, ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

Нийт удирдлагууд: Сүүлийн үед тендерийн материалын бүрдүүлэлтэд алдаа дутагдал гардаг болсон. Иймд аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ болон Орон нутгийн өмчийн газар ажлын уялдаа холбоогоо хангаж ажиллах хэрэгтэй байна. Мөн өнөөдрийн шуурхай хуралд аймгийн ерөнхий архитектор Д.Элдэвсайхан ирээгүй байна. Баярсайхан дарга Элдэвсайханд хариуцлага тооцох шаардлагатай байна. Элдэвсайхан удаа дараа ажлын хариуцлага алдаа алдаа дутагдал гаргаж байна. Мөн Мягмар гараг бүрийн өглөө хуралддаг хөрөнгө оруулалтын ажлын хуралд суух ёстой боловч суухгүй байна. Аймгийн ерөнхий архитектор тун хариуцлагагүй ажиллаж байна. Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэлд аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ хяналт тавьж ажиллах шаардлагатай байна. Аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ болон ХОХБТХ аймгийн ИТХ-ын холбогдох хороотой хамтран Барилга Захиалагчийн албаны хийж хэрэгжүүлж буй ажилд хяналт шалгалт хийх хэрэгтэй байна. Мөн аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ, багуудын дарга нартай хамтран хяналтын камерын ашиглалтад хяналт тавих хэрэгтэй байна. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын хөндлөнгийн аудитын ажлын хэсэг “Дархан Ус суваг” ХК-д ажиллаж байна. Элдэвсайханд арга хэмжээ авах хэрэгтэй. Мөн 10 жилээс дээш хугацаанд төрийн албанд ажилласан албан хаагчдыг мэргэжил дээшлүүлэх зорилгоор сургуульд сургах хэрэгтэй байна.

Хурал 10 цаг 20 минутад дуусав.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС